



МУИС-ИЙГ ДЭЛХИЙН ТҮВШИНД ХҮРГЭХ ИХ НҮҮДЭЛ, СУУДАЛ

Д.Бадарч

2022 оны 12 сарын 26

Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, эрхэм гишүүд ээ,

Энд хүрэлцэн ирсэн удирдах зөвлөлийн гишүүд, профессор багш, оюутны холбоо, багш нарын холбоо, ҮЭ болон болон багш, оюутан, ажилтан ажилчдын төлөөлөл та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Монгол үндэстний оюуны сор болсон олон арван эрдэмтэд төрүүлсэн манай улсын дээд боловсролын ууган их сургууль-МУИС хэмээх эрдмийн энэ өргөө, хамт олны дунд хоёрдахь удаагаа албан ёсоор орж байгаадаа би баяртай байна.

Би анх 1978 оны 7 сарын 1-ны өдрийн Содном ректорын 706 тоот тушаалаар МУИС-ийн ПДС-ийн ИЭЗФ-д багшаар томилогдон орж байсан юм.

Одоогоос 50 жилийн өмнө энэ алдартай дугуй зааланд улсын математикийн олимпиадаас шалгарсан бидний 10 сурагч Дашдорж багшаар олон улсын математикийн олимпиадад оролцохоор тоо заалгаж бэлтгэл хийж байснаа энэ мөчид тод санаж байна.

Юуны өмнө, баялаг түүхтэй ууган их сургуулийг удирдах нэр төртэй бөгөөд хариуцлагатай үүрэг хүлээлгэсэн Засгийн газар, БШУ, сайд Энх-Амгалан, МУИС-ийн Удирдах зөвлөл, надад итгэл хайрлаж дэмжсэн эрдэмтэн багш, ажилтан, оюутан, хамт олны төлөөлөлд талархлаа илэрхийлэхийг хүсэж байна. Мөн надад эргэлзэж санаа бодлоо ил тод илэрхийлж байсан зарим профессор багш, ажилтнуудын итгэл найдварыг хөсөрдүүлэхгүй ажиллахаа энэ индрээс баттай хэлэхийг хүсэж байна.

Эрдмийн зөвлөлийн өргөтгөсөн энэ хуралд МУИС-ийг ойрын 8-10 жилд хөгжүүлэх талаарх өөрийн бодол саналаа та бүхэнд танилцуулахыг зөвшөөрнө үү.

Юуны өмнө, боловсролын тэр дотроо дээд боловсролын хөгжлийн чиг хандлагын талаар хэдэн үг хэлье.

НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан соёлын асуудал хариуцсан төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО боловсролын хөгжлийн чиг хандлагыг ойролцоогоор 25 жилд тодорхойлж байдаг юм.

1972 онд гарсан Форийн илтгэл нь насан туршдаа сурч боловсрохын ач холбогдлыг тэмдэглэсэн бол 1996 онд дэлхийд Делорын илтгэл гэж алдаршсан бүтээлээрээ суралцахуйн 4 тулгуур баганын тухай ойлголтыг анх гаргаж тавьсан юм. 2010-аад оны үеэс дараагийн том илтгэлийг бэлтгэх шаардлага байгааг ЮНЕСКО хүлээн зөвшөөрч бэлтгэл ажилд орж байхад тэрхүү их ажлын хэлэлцүүлэгт оролцож байсан юм. Түүний дүнд завсрын тайланг гаргаж шинэ технологийн эрин үед боловсролыг талаар эргэцүүлэн бодохыг уриалсан юм.

Харин өнгөрсөн 11 сард 3 дахь том тайлангаа “Ирээдүйгээ хамтдаа төсөөлөхүй” гэсэн нэртэй гаргасан бөгөөд энэ тайлангийн үзэл санаан дор энэ жилийн турш НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын ивээл дор “Transforming Education” гэсэн дэлхийн 150 гаруй улс орныг хамарсан өргөн хүрээтэй хэлэлцүүлэг, дээд түвшний уулзалтыг зохион байгуулсан юм. Дэлхий нийтийг хамарсан энэ том арга хэмжээний үр дүнд 21-р зууны боловсролын зорилго, агуулгыг эргэн харах, ялангуяа мэдэхийн тулд бус суралцахуйд сурах, суралцагчдын хөгжлийг дэмжсэн сурах орчин бий болгох, багш нарт өөрсдийгөө өөрчлөх боломж олгох зэрэг зорилтуудыг тавьж, энэ зорилтуудыг хэрэгжүүлж, амлалтаа биелүүлэхэд манлайлал чухал болохыг онцлон тэмдэглэсэн юм.

Энэхүү арга хэмжээний хүрээнд дэлхий дахинаа дээд боловсролын их сургуулийн өөрчлөлтийн талаар дэлхийн тэргүүлэх их сургуулиуд ч санаа тавьж ажиллах болсныг энэ онд болсон Дээд боловсролын дэлхийн 3-р бага хурал, сүүлийн үеийн ном хэвлэлүүдээс харж болно.

“Transforming Education” гэдгийг эх газрын улс орнууд tectonic shift гэж тайлбарлаж байхад далайн улс орнууд Big Wave гэж хүлээж авч байна. Харин нүүдэлчин бидний хувьд боловсролын энэ хувьсал өөрчлөлтийг их нүүдэл суудал гэж авч үзвэл илүү тохиромжтой болов уу гэж би үзэж байгаа юм.

Тийм учраас МУИС-ийг хөгжүүлэх төлөвлөгөөний үзэл санааг МУИС-ийг дэлхийн түвшинд хүргэх их нүүдэл суудал гэж би томъёолсон юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа МУИС-ийн ололт амжилт, стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийхийг оролдсон юм.

80 жилийн түүхэндээ МУИС бакалаврын түвшний онолын мэдлэг, чадварыг дэлхийн түвшинд олгодог болсныг манай судлаачид төдийгүй гадаадын нэр

хүндтэй байгууллага, эрдэмтэд тэмдэглэж байна. Сүүлийн арваад жилд МУИС судалгааны их сургууль болох зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлсний дүнд орчин үеийн тоног төхөөрөмж бүхий судалгааны 40 гаруй лаборатори, түүнд ажилладаг залуу эрдэмтэн судлаачид, судалгааныхаа ажлын үр дүнг дэлхийн нэр хүндтэй сэтгүүлүүдэд нийтлүүлж үнэлж дүгнүүлдэг болсон байна. МУИС-ийн эрдэмтэн багш нараас 44 патент, 21 ашигтай загвар бүртгүүлж, олон улсын сайн шүүлттэй сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн тоогоороо бусад их сургуулиудаас тасарч ШУА-ын дараа орж байгаа тэмдэглэн хэлэхэд таатай байна. Өөрөөр хэлбэл, МУИС судалгааны их сургуулийн соёлыг төлөвшүүлж эхэлсэн байна.

Их сургуулийн хамт олноос стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар бүхий үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллаж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Өнгөрсөн 2 сар хагасын хугацаанд МУИС-ийн хамт олны төлөөлөл, тэргүүлэх профессор, эрдэмтэд, зарим нэг тэнхим нэгжийн хамт олонтой уулзаж байхад их сургуулийн цаашдын хөгжлийн талаар санаа бодлоо хуваалцаж байсан юм. Эндээс их сургуулийн удирдлагыг нээлттэй, ил тод, шуурхай, хариуцлагатай болгох, удирдах ажилтнуудыг чадваржуулах, бүтэц зохион байгуулалтыг цомхон, үр өгөөжтэй болгох, их сургуулиас үлс орны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцох хувь нэмрийг мэдэгдэхүйц хэмжээнд хүргэх, санхүүгийн сахилгыг дээшлүүлэх, дүрэм журмын уялдаа холбоог сайжруулах зэрэг санал гарч байлаа.

Энэ бүхний үндсэн дээр МУИС-ийг дэлхийн түвшинд хүргэх их нүүдэл суудал гэсэн төлөвлөгөөг боловсруулсан юм.

МУИС бол өөрийнхөө мэргэшлийн чиглэлд манлайлагч болсон олон мундаг эрдэмтэдтэйгээр улсынхаа хэмжээнд төдийгүй дэлхийд танигдаж байгаа их сургууль юм. 2 сар гаруйн хугацаанд би монгол хэл бичиг, түүх археологиос биологи, молекул генетик, биотехнологи, хүрээлэн буй орчны судалгаанаас биоинформатик, математик загварчлал, лазерын технологиос нано технологи, биологийн төрөл зүйл, ойн эко систем, ойн генетикийн зэрэг олон чиглэлээр ажиллаж байгаа нэртэй эрдэмтэдтэй уулзаж тэдний бүтээл туурвилаас сонсоход урам сэргэж байлаа. Цаг хугацааны бололцооноос болж бусад мэргэжлийн нэртэй олон эрдэмтэдтэй уулзаж амжаагүйг минь ойлгох биз ээ.

Гэхдээ манай хууль зүй, бизнес, олон улсын харилцаа, эдийн засаг, орон судлал, нийтийн удирдлага, хэрэглээний шинжлэх ухаан, мэдээллийн технологи, хиймэл оюун, нийгэм хүмүүнлэгийн зэрэг бусад салбаруудын эрдэмтэн багш судлаачдын арвин их бүтээл түүрвил, амжилт бүтээлийн талаар би сонсож мэдэж авсан. Удахгүй газар дээр нь очиж танилцах болно.

Манай профессор багш нар оюутандаа нэг талаас либерал арт, нөгөө талаас нарийн мэргэжлийн мэдлэгийг хослуулан эзэмшүүлэхийн төлөө оюуны хүч, заах арга зүйн арга технологио чиглүүлж байгааг, мөн мэдлэгийг зөвхөн түүнийг бүтээхийн тулд бус түүнийг ашиглан нийгэмдээ эерэг нөлөө үзүүлэхийн төлөө ажиллаж байгааг онцгойлон тэмдэглэмээр байна.

Энэ бүхэн чанартай судалгаа явуулж, судалгааны их сургууль болох зорилгыг тэргүүн зэрэгт тавих үндэслэл болсон юм. Миний зүгээс МУИС-ийг судалгааны үндэсний их сургуулийн статустай болгохын тулд өөрийн мэдлэг чадвараа чиглүүлэн ажиллах болно.

Дараагийн том тэргүүлэх чиглэл бол чанартай боловсрол олгоход чиглэх ёстой гэж үзэж байна. Манай их сургуулийн эрдэмтэн багш нар оюутан залуучуудаа олон улсын олимпиадад бэлтгэн дэлхийн түвшинд их сургуулийнхаа төдийгүй, улс орныхоо нэрийг гаргаж байгаа нь манай их сургуулийн боловсролын түвшнийг шууд илэрхийлж байна. Өнөөдөр мэдлэгийг дамжуулах бус харин суралцахууд сургах явдал эн тэргүүний зорилт болж байгаа нөхцөлд оюутан залуучуудын суралцах хувийн төлөвлөгөөг улам боловсронгуй болгож, тэдэнд өөрийн хүсэл сонирхол, авьяас чадварыг харгалзан сурах боломжийг нээж өгөхөд орчин үеийн шинжлэх ухааны тухайлбал, нейросайнс, мэдээллийн технологийн ололт, амжилтыг ухаалгаар хэрэглэх сурах үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч, сурах, сургах үйл ажиллагаанд цоо шинэ арга барил, инновацийг нэвтрүүлэхэд манай эрдэмтэн багш нар манлайлагч байж чадна гэдэгт итгэлтэй байна.

Гуравдах тэргүүлэх чиглэл бол чанартай төгсөгч бэлтгэхэд бүхий л анхаарлаа хандуулах явдал юм. Сүүлийн арав гаруй жил МУИС оюутан залуучуудын сурах орчныг сайжруулах, сурч боловсрох, авьяас чадвараа нээж хөгжих боломжийг өргөтгөх зорилгоор их сургуулийн номын сан, багш оюутанд үйлчлэх төвийн барилгыг барьж ашиглалтад оруулж байна. Энэ бол МУИС-ийг удирдаж байсан өмнөх удирдлагуудын алсын хараа, оновчтой шийдэл байсан гэдгийг зориуд

тэмдэглэж байна. Өнөөдөр оюутан залуучуудыг хөгжүүлэх асуудлыг бодлогоор дэмжин, тусалж, их сургуулийн жилүүдэд онолын гүнзгий мэдлэгээс гадна Liberal art-аар гэгээрч, хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй, насан туршдаа сурч, нээж бүтээх, шинэ санааг дэвшүүлж, үнэнийг байнга эрэлхийлдэг болгоход дэмжлэг үзүүлэх шаардлага эрс нэмэгдэж байна.

Дөрөвдэх чиглэл бол Их сургууль-төр-бизнес үйлдвэрлэл-нийгмийн хоорондын нягт уялдаа бүхий итгэлцэл дээр үндэслэсэн дөрвөлсөн холбоог бий болгох замаар **“Чанартай үйлчилгээ нийгэмд хүргэх”** зорилгыг хэрэгжүүлнэ.

Нийгэмд чанартай үйлчилгээ үзүүлэх талаар хийж байгаа ажлынхаа цар хүрээг өргөтгөх шаардлага тулгарч байгааг бид өмнөх стратегийн төлөвлөгөөний биелэлтийн явцаас харсан билээ. Энэ чиглэлээр хийх ажлын чиглэл, арга хэлбэрийг цоо шинээр дизайн хийж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Юуны өмнө, шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн мэдлэг, мэдээллийг нийгэмд хүргэж, хүүхэд залуучууд, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд манай их сургууль чухал үүрэг гүйцэтгэх үүрэгтэй. Нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарц, шийдлүүдийн талаар нэр хүндтэй тайлан, бодлогын зөвлөмж зэргийг тогтмол гаргаж, судалгаа, баталгаа нотолгоонд тулгуурласан мэдээллээр олон нийтийг хангах замаар улс орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулах соёлыг нэвтрүүлнэ.

Улс орны хөгжлийн асуудлаарх мега төслүүдэд оролцож, мэргэжлийн өндөр түвшний зөвлөмж шийдлүүдийг гаргаж өгдөг нэр хүндтэй төв болно.

Дээрх чиглэлүүдийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөлийг манлайлал, ухаалаг удирдахуйн стратегийг хэрэгжүүлж, өндөр бүтээмжтэй удирдлагын тогтолцоог бий болгох явдал юм. Үүний тулд дараах чиглэлээр ажиллах шаардлагатай байна.

- Санхүү. Санхүүгийн сахилгыг дээшлүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг бий болгож, санхүүгийн өндөр мэдлэг үр чадвартай баг бүрдүүлнэ. Орлогын эх үүсвэрийг тогтвортой нэмэгдүүлэх арга замыг хайж, сургалт судалгааны ажлын зардлын тооцоог бодитой үндэслэл сайтай хийж, багш хамт олонд хүрэлцээтэй хэмжээний цалин

урамшуулал олгох ажлыг дэс дараатай хийх явдал чухлаар тавигдаж байна.

- Үйл ажиллагаа. Удирдах үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд удирдах болон захиргааны ажилтнуудын мэдлэг, удирдах үр чадвар, харилцааны соёлыг тогтмол дээшлүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг явуулахдаа үр дүнд суурилсан менежмент, 180°, 360° зэрэг дэвшилтэт аргуудыг хэрэглэж тэдний манлайллыг дээшлүүлнэ.
- Хүний нөөц. Авьяасын тогтвортой хангалт, төвлөрлийг бий болгох замаар үйл ажиллагааны чанарыг сайжруулах зорилгыг хангана.
- Шийдвэр гаргах. Их өгөгдөл, судалгаа нотолгоонд тулгуурласан хамтын шийдвэрийг гаргаж хэрэгжүүлдэг, шуурхай, үр өгөөжтэй, чадварлаг удирдлагын багтай болно.
- Аюулгүй байдал. Хамт олны аюулгүй байдал, сурч боловсрох, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, хамт олны эрүүл мэндийг хамгаалахад онцгой анхаарч ажиллана.
- Бүтэц. Оновчтой, үр бүтээлч, цомхон захиргааны бүтцийг бий болгож, удирдлагын үйлчилгээний соёлыг нэвтрүүлнэ. МУИС нь манай орны нийслэл хот болон баруун, зүүн бүсийг хамарсан оюуны төв -эрдмийн уурхай болно. Удирдах албан тушаалд мерит зарчимд тулгуурлан юуны өмнө хамт олны дотроос шалгаруулан томилох журмыг мөрдлөг болгон ажиллана.
- Хамтын ажиллагаа. Мэдлэг бүтээх, судалгаа хийх, кредит хүлээн зөвшөөрөх зэрэг олон талын хамтын ажиллагааг юуны өмнө төрийн өмчийн 5 их сургуультай хөгжүүлж монголын дээд боловсролын хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах ажлыг манлайлан ажиллана.

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд дээрх бүх өөрчлөлт шинэчлэл, нүүдэл суудлыг амжилттай хийх нэг нөхцөл бол бид бүхэн сэтгэлгээний өөрчлөлт mindset shift хийх явдал юм.

Их сургуулийн хамт олон нэгдмэл нэг зорилгын дор нэгдэж, чөлөөт сэтгэлгээ, академик эрх чөлөөг дээдлэн хамгаалж, аливаа асуудалд хүлээцтэй, үнэнд хүрэхийн тулд баримт нотолгоонд тулгуурлахыг эрмэлзэж, хувь хүний нэр төр, эрхийг хамгаалж чаддаг олон ургалч үзэл, тэгш эрх, хариуцлагатай хамт олон болж хөгжихийг эрхэмлэх хэрэгтэй. Ингэж байж бид нийгмийнхээ өмнө

хүлээсэн ёс зүйн хариуцлагаа бүрэн хэрэгжүүлж, ардчилсан, чөлөөт нийгмийг бүтээн байгуулахад дорвитой хувь нэмэр оруулах болно.

80 жилийн түүхтэй манай ууган их сургууль нь улс эх орныхоо хөгжил дэвшилд тодорхой үүрэг гүйцэтгэж ирсэн юм. Өнгөрсөн хугацаанд МУИС-аас дээд боловсролын хөгжилд оруулсан хувь нэмрийн зарим нэг гол ололтыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Байгалийн шинжлэх ухааны онолын суурь мэдлэгийн түвшин нь монголдоо төдийгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрсэн байна.
2. Хууль, нийгэм хүмүүнлэг, олон улсын харилцаа, эдийн засаг, бизнесийн зэрэг чиглэлийн сургалтын түвшин нь улс орныхоо түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй олон улсад ч хүлээн зөвшөөрөгдөж эхэлж байна.
3. Судалгааны ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд өндөр шаардлага тавьж ажилласны үр дүнд судалгааны их сургуулийн суурийг тавьж, соёлыг төлөвшүүлж эхэлсэн байна. Судалгааны төв, хүрээлэн, лабораториуд нь санхүүгийн хувьд бие даан ажиллаж, үйл ажиллагааны зардлаа өөрсдөө бий болгодог журмыг хэрэгжүүлж байгаа нь сайн талтай юм.

ЮНЕСКО-оос тодорхойлсон дэлхийн дээд боловсролын хөгжлийн замын зураглалын дагуу болон тус их сургуульд сар гаруй хугацаанд ажиллаж, эрдэмтэн профессоруудын төлөөлөлтэй санал солилцсоны дүнд МУИС-ийг цаашид хөгжүүлэхэд анхаарах гол асуудлыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. МУИС-ийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөө нь 4 зорилго, 11 зорилт, 64 стратеги, 123 KPI үзүүлэлтийг агуулж байгаа бөгөөд саяхны хийсэн гүйцэтгэлийн үнэлгээгээр дараах дүр зураг харагдаж байна.
 - a. Зорилго 2. Сургах, суралцах үйл явцыг дэлхийн түвшинд хүргэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын 58 үзүүлэлт 47%-ийн биелэлттэй байна.
 - b. Зорилго 1. Судалгааны хамрах хүрээг өргөжүүлж, түвшнийг дэлхийн жишигт хүргэх зорилгыг хэрэгжүүлэх 30 үзүүлэлт 24%-ийн биелэлттэй байна.
 - c. Зорилго 4. Байгууллагын бие даасан байдлыг хангаж, менежментийн олон улсын шилдэг арга барилыг нэвтрүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгыг хэрэгжүүлэх 24 үзүүлэлт 19%-ийн биелэлттэй байна.

- d. Зорилго 3. Нийгэмд мэдлэгээр манлайлж, нийгмийн хөгжлийн түүчээ байх зорилгыг хэрэгжүүлэх 11 үзүүлэлт 9%-ийн биелэлттэй байна.

Багш нарын төлөөлөлтэй хийсэн үүлзалт, өөрийн ажилласан хугацаанд ажиглагдсан нөхцөл байдлаас харахад МУИС-ийн хувьд цаашид их сургуулийн удирдлагыг ил тод, нээлттэй, өндөр бүтээмжтэй, цомхон, хариуцлагатай болгох шаардлага тулгарч байна. Ер нь удирдах ажилтны чадвар шаардлагын түвшинд хүрэхгүй байгаа нь харагдаж байна. Мөн их сургуулийн зохион байгуулалтын бүтцийг их сургуулийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлэн өөрчилж шинээр дизайн хийх цаг болсон байна. Их сургуулиас нийгэм эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмрийг эрс дээшлүүлэх бодит шаардлага байна.

2. Их сургуулийн санхүүгийн менежментийг эрс сайжруулж, санхүүгийн сахилгыг дээшлүүлэх шаардлага байна гэж үзэж байна. Их сургуулийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, зардлын норм, норматив тогтоох, нэгж хэсгүүдийн санхүүгийн сахилга, менежментийг сайжруулах шаардлага нэн тэргүүний шийдвэрлэх асуудал гэж үзэж байна.
3. Их сургуулийн дотоод дүрэм журмыг өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн шинэчлэлд нийцүүлж, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах шаардлага гарч ирж байна. Мөн хөдөлмөрийн сахилгыг сахиулах, зөрчил дутагдлыг даруй илрүүлж, арга хэмжээ авах, ёс зүйн асуудлыг шуурхай шийдвэрлэх тогтолцоо сул байдаг учраас сүүлийн жилүүдэд ажлаас халагдсан 10 гаруй хүмүүст шүүхийн шийдвэрээр их сургууль их хэмжээний нөхөн төлбөр олгосон байна.

2. Монгол улсын их сургуулийг хөгжүүлэх хөтөлбөрийн талаарх миний санал

2022 оны 9 сард НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын санаачилгаар болсон боловсролын асуудлаарх дээд түвшний үүлзалт, ЮНЕСКО-оос 2022 оны 5 сард зохион байгуулсан Дээд боловсролын дэлхийн III бага хурал, Дээд боловсролын хөгжлийн 2032 он хүртэлх замын зураглал зэрэг баримт бичгийг судалж, Монгол улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр “Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлого, өөрийн орны нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, дээд боловсролын хөгжлийн өнөөгийн байдал, одоо хэлэлцэгдэж байгаа боловсролын эрх зүйн шинэчлэлийн багц хуулийн үзэл санаа, МУИС-ийн 80 жилийн хөгжлийн ололт амжилт, өнөөгийн байдлын ажиглалт, зарим нэг судалгааны үндсэн дээр МУИС-ийг цаашид хөгжүүлэх хөтөлбөрийн ерөнхий дүр зургийг дараах байдлаар томъёолон толилуулж байна.

Алсын хараа

МУИС-ийг хөгжүүлэх дунд хугацааны алсын хараа, зорилго нь их нүүдэл, суудал хийж МУИС-ийг 2030 он гэхэд дэлхийн түвшинд хүргэх явдал юм. Ийм бололцоо байгаа гэдэгт итгэлтэй байна.

Хүрэх арга зам

1. Их сургуулийн бүхий үйл ажиллагааны чанарыг эрс дээшлүүлж, улс орныхоо хэрэгцээ шаардлагад нийцсэн төгсөгч мэргэжилтэн бэлтгэх, улс орныхоо хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулах судалгаа шинжилгээний ажил явуулах, нийгэмдээ чанартай үйлчилгээ үзүүлэх
2. Академик эрх чөлөө, либерал арт (гэгээрэх урлаг), нээлттэй боловсрол, нээлттэй шинжлэх ухаан зэрэг боловсролын философиог үйл ажиллагааныхаа үзэл баримтлал болгон ажиллах
3. Цахим технологийн давуу талыг үйл ажиллагааныхаа бүхий л салбарт ухаалгаар хэрэглэх
4. Олон улсын хамтын ажиллагааг үйл ажиллагааныхаа үр өгөөжийг дээшлүүлэхэд ухаалгаар хөгжүүлэх замаар дэлхийд танигдах

Үндсэн үйл ажиллагааны гол зорилгууд

Чанартай судалгаа

Чанартай боловсрол

Чанартай төгсөгч


Өндөр бүтээмжтэй удирдлага

Нийгэмд чанартай үйлчилгээ үзүүлэх

МУИС-ийг дэлхийн түвшинд хүргэх их нүүдэл суудал хийх замаар хөгжүүлэх хөтөлбөрийн бүдүүвчийг зурагт үзүүлээ.



Зураг. МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙГ ДЭЛХИЙН ТҮВШИНД ХҮРГЭХ ИХ НҮҮДЭЛ, СУУДАЛ



Зорилгыг хэрэгжүүлэх стратеги

- 1. Мэдлэг бүтээх, хэрэглэх стратеги.** Энэ стратеги нь “Чанартай судалгаа” зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.
 - Суурь судалгааг дэмжиж, шинжлэх ухааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулна.
 - Нийгмийн тулгамдсан асуудлаар судалгаа явуулж, үр дүн, инновацыг нэвтрүүлэх судалгааны орчныг бий болгож, улс орны хөгжилд бодитой хувь нэмэр оруулна.
 - Их сургуулийн судалгааны орчин үеийн лабораторийн баазын ашиглалтыг сайжруулж, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд шинэ технологийг ашиглах, лабораторийн үйл ажиллагааг дэмжих бүтцийг бий болгох, судалгааны ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх оюуны өмчийн үйлчилгээ, гэрээ эрх зүйн дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авна.
 - Үндэсний судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх ахисан түвшний чанартай сургалтыг явуулах, шинэ үеийн судлаачдыг бэлтгэнэ.
 - Монгол улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр “Алсын хараа-2050”, шинэ сэргэлтийн бодлого болон дунд хугацааны тулгамдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд их сургуулийнхаа оюуны хамтын хүчийг дайчлан тэргүүлэх чиглэлээр бодлогын зөвлөмж гаргах, хэрэгжүүлэх шийдлийн шинжлэх ухааны баталгаа нотолгоонд үндэслэсэн хувилбаруудыг боловсруулж, судалгааны ажлын манлайлагч-оюуны төв болно.
 - Нээлттэй шинжлэх ухааныг хөгжүүлэх замаар шинжлэх ухааны ололт амжилтыг сурталчлах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам, шийдлүүдийг танилцуулах замаар нийгмийн зүгээс шинжлэх ухаанд итгэх итгэл үнэмшлийг дээшлүүлнэ.

2. *Суралцахууд суралцах стратеги.* Шинжлэх ухааны орчин үеийн дэвшилтэт арга технологи, тухайлбал нейросайнс, дэвшилтэт арга зүй (transformative pedagogy), (digital pedagogy) зэргийг ухаалгаар хэрэглэх замаар **“Чанартай боловсрол”** эзэмших боломж олгох зорилгыг хэрэгжүүлнэ.
- Суралцагч төвтэй, судалгаа, туршилтаар бататгасан, чадамжид тулгуурласан, цахим дэвшилтэт заах аргаар хувь хүн бүрийн сонирхол, онцлогт чиглэсэн боловсрол олгох нөхцөлийг бүрдүүлнэ.
 - Эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангахуйц, үр чадварын зөрүүг арилгахуйц уян хатан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
 - Сургалтын нээлттэй нөөц материал, онлайн хичээл зэргийг системтэйгээр шинэлэг арга замаар бий болгон, бүх хүмүүст насан туршдаа боловсрол эзэмших боломжийг өргөжүүлэн дэмжинэ.
 - Сургалтын хөтөлбөрийн цөм нь шинжлэх ухааны салбар хоорондын уулзварын мэдлэг чадварыг олгох, бүтээлч сэтгэлгээ, үнэнийг эрэх үр чадварыг хөгжүүлэхэд чиглэн, аливаа асуудлыг шийдвэрлэхэд мэдлэгээ хэрэглэх чадамжийг төлөвшүүлэхэд чиглэнэ.
 - Мэдээллийн үнэн зөвийг ялган салгаж чаддаг, тогтвортой хөгжлийг дэмжигч, нийгмийн хариуцлагатай, хамтач, үнэнч шударга, ёс зүйтэй иргэн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлнэ.
 - Сургалтын чанарыг тогтмол сайжруулах соёлыг төлөвшүүлнэ.
3. *Оюутныг хөгжүүлэх стратеги.* Оюутан залуучуудыг бүх талаар хөгжүүлж, өндөр түвшний мэргэжлийн мэдлэг эзэмших боломжоор хангахын зэрэгцээ ажил дээр шууд гарах “зөөлөн үр чадвар”-ыг эзэмшүүлэх замаар **“Чанартай төгсөгч”** бэлтгэх зорилгыг хэрэгжүүлж, төгсөгчидтэй тогтмол холбоо тогтоож, тэдэнд насан туршдаа сурч боловсрох боломж олгоно.
- Оюутанд сурах орчныг бүрдүүлж, ажил эрхлэх чадвар, зөөлөн үр чадвар эзэмших боломжийг өгч тэднийг гэгээрүүлж хөгжүүлнэ.
 - Оюутны эрэлт хэрэгцээ, хүлээлт, хүсэл мөрөөдлийг явцын сорил, үнэлгээ, их өгөгдөлд тулгуурлан таньж авч, тэдэнд тогтмол тусалж дэмжлэг үзүүлнэ.
 - Суралцахууд суралцах, өөрийгөө хөгжүүлэх олон төрлийн арга хэмжээг зохион байгуулна.
 - Оюутанд өөрийн авьяас чадвараа нээх боломж олгож дэмжинэ.
 - Төгсөгчдөд зориулсан богино хугацааны мэргэжлийн дээд түвшний сургалтыг захиалгаар болон тусгай хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

4. *Манлайлал, ухаалаг удирдахуйн стратеги.* Удирдлага, манлайллын орчин үеийн арга барилыг амьдралд хэрэгжүүлэх замаар **“Өндөр бүтээмжтэй их сургууль”** болох зорилгод хүрнэ.
- Санхүү. Санхүүгийн сахилгыг дээшлүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг бий болгож, санхүүгийн өндөр мэдлэг үр чадвартай баг бүрдүүлнэ.
 - Үйл ажиллагаа. Үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд удирдах болон захиргааны ажилтнуудын мэдлэг, удирдах үр чадвар, харилцааны соёлыг тогтмол дээшлүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг тогтмол явуулж, тэдний манлайллыг дээшлүүлнэ.
 - Хүний нөөц. Авьяасын тогтвортой хангалт, төвлөрлийг бий болгох замаар үйл ажиллагааны чанарыг сайжруулах зорилгыг хангана.
 - Бүтэц. Оновчтой, үр бүтээлч, цомхон захиргааны бүтцийг бий болгож, удирдлагын үйлчилгээний соёлыг нэвтрүүлнэ. МУИС нь манай орны нийслэл хот болон баруун, зүүн бүсийг хамарсан оюуны төв -эрдмийн үүрхай болно.
 - Шийдвэр гаргах. Их өгөгдөл, судалгаа нотолгоонд тулгуурласан хамтын шийдвэрийг гаргаж хэрэгжүүлдэг, шуурхай, үр өгөөжтэй, чадварлаг удирдлагын багтай болно.
 - Аюулгүй байдал. Хамт олны аюулгүй байдал, сурч боловсрох, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, хамт олны эрүүл мэндийг хамгаалахад онцгой анхаарч ажиллана.
 - Хамтын ажиллагаа. Мэдлэг бүтээх, судалгаа хийх, кредит хүлээн зөвшөөрөх зэрэг олон талын хамтын ажиллагааг юуны өмнө төрийн өмчийн 5 их сургуультай хөгжүүлж монголын дээд боловсролын хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах ажлыг манлайлан ажиллана.
 - Гадаад харилцаа. Олон улсын хамтын ажиллагааг үр бүтээлтэй хөгжүүлэх талаар бодлого хэрэгжүүлж, тодорхой чиглэлээр олон улсын сургалт судалгааны төвүүдтэй болно.
5. Их сургууль-төр-бизнес-нийгмийн дөрвөлсөн холбоо стратеги. Их сургууль-төр-бизнес үйлдвэрлэл-нийгмийн хоорондын нягт уялдаа бүхий итгэлцэл дээр үндэслэсэн дөрвөлсөн холбоог бий болгох замаар **“Чанартай үйлчилгээ нийгэмд хүргэх”** зорилгыг хэрэгжүүлнэ.
- Нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө өгөх нэр хүндтэй төв болно.
 - Нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарц, шийдлүүдийг судалгаа, баталгаа нотолгооны үндсэн дээр гаргаж өгч улс орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулах соёлыг нэвтрүүлнэ.
 - Шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн мэдлэг, мэдээллийг нийгэмд хүргэж, хүүхэд залуучууд, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.
 - Нийгмийн тулгамдсан асуудлаар нэр хүндтэй тайлан, бодлогын зөвлөмж зэргийг тогтмол гаргаж, үнэн зөв баталгаа нотолгоотой мэдээллээр олон нийтийг хангана.

- Их сургуулийнхаа нэр хүндийг эх орондоо болон олон улсад өндөрт өргөж явна.

---o0o---